

Хураангуй

Дэлхийн эдийн засаг гүнзгий хямралд орсны дараа улсаас эрэлтэд чиглэсэн өргөн хүрээтэй дэмжлэг үзүүлсний дүнд эдийн засаг сэргээж эерэг өсөлт бий боллоо. Мөн санхүүгийн зах зээл дэх тодорхой бус байдал болон системийн эрсдэл буурчээ. Эдийн засгийн сэргэлт нь санхүүгийн систем хүндрэлтэй хэвээр байгаа, төсвөөс үзүүлж буй бодлогын дэмжлэгийг аажимдаа хумих шаардлага, хөрөнгийн үнийн огцом өсөлтөөс цохилтод орсон айл өрхүүд ажилгүйдэлтэй тэмцэхийн зэрэгцээ хуримтлалаа эргэн нэмэгдүүлэх зэрэг шалтгаанаар удааширах төлөвтэй байна. Эдийн засаг сэргээж хөл дээрээ баттай зогсох хүртэл макроэдийн засгийн бодлогыг дэмжихийн хамт санхүүгийн системийг сэргээхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн шаардлага хэвээр үлдэнэ. Гэхдээ бодлогын шийдвэр гаргагчид нь төсвийн хэт оролцоог дэс дараатайгаар бууруулахад бэлтгэж эхлэх хэрэгтэй.

Дэлхийн хямрал дуусгавар болж байгаа ч цаашид эдийн засаг аажмаар сэргэх төлөвтэй байна.

Азийн эдийн засгийн үзүүлэлт сайн байгаа болон ерөнхийдөө нийт улсуудад бага зэргийн сэргэлт бий болсон эсвэл тогтворжсонтой холбоотойгоор дэлхийн эдийн засаг дахин өсөх хандлагатай болов. Хөгжингүй эдийн засагт урьд өмнө тохиолдож байгаагүй төрийн оролцоо үйл явцыг тогтворжуулж хэд хэдэн оронд бага зэргийн өсөлт гарсан байна. Азийн улс орнуудын эдийн засаг дахин өсч эхэлснээр хөгжиж буй болон хөгжингүй улс орнууд ерөнхийдөө цаашдын сэргэлтийн замдаа ороод байна. Бараа түүхий эдийн саяхны үнийн өсөлт болон дэмжлэг болохуйц бодлого нь дээрх улс орнуудын ихэнхэд тус нэмрээ харууллаа. Европын хөгжиж буй олонхи улс орнууд болон Тусгаар Тогтносон Улсуудын Хамтын Нөхөрлөл (ТТУХН)-ийн орнуудад хямрал хүнд туссан бөгөөд эдгээр улсуудын хөгжил ерөнхийдөө хоцрогдсон хэвээр байна. Сэргэлтийн хурд удааширалтай байгаа бөгөөд хямралын өмнөх түвшинтэй харьцуулахад тун мэдэгдэхүйц бага байна. Энэ сэргэлтэд үйлдвэрлэлийн салбарт гарсан огцом өсөлт, бараа материалын мөчлөг дэх эргэлт болон жижиглэн худалдааны аажим тогтворжилт гол үүрэг гүйцэтгэж байна. Цаашид төлөв байдал сайжрахын хамт бараа түүхий эдийн үнэ энэ оны эхний үед байсан доогуур түвшнээс өсч дэлхийн худалдаа сэргэх байдалтай байна.

Энэ огцом өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс нь хөгжингүй болон олонхи хөгжиж буй орнуудад хэрэгжүүлсэн эрэлтийг дэмжих төсвийн хүчтэй бодлого байсан бөгөөд дэлхийн хэмжээнд бараа бүтээгдэхүүний үнэ унана гэсэн айдас бүрэн хэмжээгээр арилсан байна. Энэ айдас нь дэлхийн хэмжээний үйл ажиллагаа болон худалдааг Дэлхийн II дайнаас хойш анх удаа огцом буурахад хүргэсэн байна. Төв банкууд нь хүүгийн түвшинг ер бусын их хэмжээгээр бууруулах, дахин хөрөнгөжүүлэх болон зээлийг хадгалж үлдэх уламжлалт бус арга хэмжээг авч хариу үйлдэл хурдан үзүүлэв.

Засгийн газрууд банкуудад баталгаа гаргаж, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэхийн хамт төсвөөс эдийн засгийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр арга хэмжээ нь хамтдаа тодорхой бус байдлыг сааруулж санхүүгийн нөхцөл сайжирахад итгэх итгэлийг нэмэгдүүлсэн нь олон зах зээлд өрсөлдөөн хүчтэй болж олон улсын хөрөнгийн урсгал огцом өссөнөөс харагдаж байна. Гэхдээ, жижиг зээлдэгчдийн хувьд

бизнесийн орчин нь маш төвөгтэй хэвээр байна. 2009 оны 10-р сарын *Дэлхийн Санхүүгийн Тогтвортой Байдлын Тайлан* (GFSR) –д онцлон дурдсаны үзэхэд ерөнхийдөө урвуу эрсдэл нь том зах зээлийн асуудал бөгөөд санхүүгийн цочролын зарим үзүүлэлт өсөлттэй хэвээр байна. Огцом өсөлт рүү түлхэж байсан одоогийн бодлогын үйлчлэлийн хүч аажмаар саарах ба гэхдээ яваандаа бий болох бодит болон санхүүгийн үйлчлэл сул хэвээр байх төлөвтэй байна.

Ялангуяа, төсвөөс үзүүлэх эдийн засгийн дэмжлэг хумигдаж, бараа материалын нөлөөлөл аажмаар буурна. Үүний зэрэгцээ, олонхи улс орны санхүүгийн нөхцөл байдал хүнд хэвээр байгаа тул хэрэглээ болон хөрөнгө оруулалтийн өсөлт удаан хэвээр байна. Ийнхүү, дэлхийн эдийн засаг 2009 онд 1 орчим хувиар буурсны дараагаар 2010 онд 3 орчим хувиар өсөхөөр байгаа нь хямралын өмнөх үеийн хүрсэн түвшнээс маш доогуур байна. Эдгээр урьдчилсан төсөөлөл нь 2009 оны 7-р сарын *Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв байдлын шинэчилсэн тайлан* (WEO)-д тусгагдсан үзүүлэлтүүдийг бага зэрэг өсгөхөөр байна.

- Хөгжингүй улс орнуудын эдийн засаг 2010 оны дийлэнхи хугацаанд маш удаан тэлэх ба энэ оны сүүлч хүртэл ажилгүйдлийн хэмжээ өссөн хэвээр байна. 2010 оны эдийн засгийн жилийн өсөлт 1.25 орчим хувь байхаар тооцоолж байна. Харин 2009 онд энэ үзүүлэлт 3.5 орчим хувь байв. 2010 оны 4-р улирлын үйл ажиллагааг 2009 мөн үеийнхтэй харьцуулбал сэргэлт гарах нь илүү тодорхой болж байна. ДНБ-ий бодит өсөлтийг 1.75 хувь байхаар тооцоолж байна. Харин 2009 оны сүүлийн хагас жилийн эдийн засгийн өсөлт 0.5 хувь (жилийн) байх, эхний хагас жилд 2 хувиар буурах төсөөлөл байна.

- Хөгжиж буй улс орнуудын ДНБ-ий бодит өсөлт 2009 онд 1.75 хувь байхаар хүлээгдэж буй бол 2010 онд бараг 5 хувьд хүрнэ гэсэн төсөөлөл байна. Энэ огцом өсөлтөд Хятад, Энэтхэг болон Азийн бусад хөгжиж буй улс орнуудын эдийн засгийн хөгжил нөлөөлсөн. Хөгжиж буй бусад улс орнуудад гарсан бага зэргийн өсөлт нь бодлогын хүрээний дэмжлэг болон дэлхийн худалдаа, санхүүгийн нөхцөл сайжирч байгаагийн үр дүн юм.

Эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэл аажмаар буурах хэдий ч санаа зовоосон зарим асуудлууд хэвээр байна. Үүсч болзошгүй богино хугацааны гол эрсдэл нь сэргэлт зогсонги байдалд орох явдал юм. Дэмжлэг болж буй төсөв, мөнгөний бодлогоо цагаас нь эрт зогсоох явдал томоохон эрсдэлд тооцогдоно. Учир нь хувийн эрэлт хэрэглээний хүчтэй сэргэлтийн эхэн үед бодлогоор сэргэсэн огцом өсөлт гаргах нь буруу байж мэднэ. Ерөнхийдөө, дэлхийн эдийн засаг хэврэг байгаа нь хэд хэдэн цочрол, тухайлбал нефтийн үнийн өсөлт, H1N1 вирусын тархалт, геополитикийн бодлого эсвэл дахин сэргэсэн протекционизм зэрэгт өртөх магадлал хэвээр байгааг харуулж байна.

Саяхны нөхцөл байдлаас харахад богино хугацааны эрсдэл нь сул талтай байдаг ч нөгөө талаар төсөөлж байснаас хурдан санхүүгийн нөхцөл байдлыг сайжруулж байна. Ялангуяа, 1930-аад оных шиг уналт гарахаас болгоомжилсноос болж бодлогоор өдөөгдсөн үйл ажиллагааг хязгаарласнаас санхүүгийн зах зээлд гарсан огцом өсөлт нь хөгжингүй ба хөгжиж буй зарим улс орны хэрэглээ болон хөрөнгө оруулалт төсөөлж байснаас илүү нэмэгдэхэд хүргэж болно.

Хэтийн төлөв байдлыг дунд хугацаанд шилжүүлэн үзэхэд хөгжингүй том улс орнуудад ихэнхдээ явагдах тасралтгүй сэргэлтээс улбаалж том эрсдэлүүд урган гарна.

Санхүүгийн талаас нь авч үзвэл, хямралын хариуцлагыг хүлээх ёстой компаниудыг аврах нь санхүүгийн салбарт бүтцийн өөрчлөлт хийхэд шаардагдах төсвийн дэмжлэгийг бууруулахад хүргэж байна гэж үзэх олон нийтийн үл итгэх байдал санаа зовоосон гол асуудал болж байна. Ийнхүү, урт хугацааны туршид зогсонги байдалд оршиход хүрч байна. Макро эдийн засгийн бодлогын талаас нь авч үзвэл, санхүүгийн салбарыг дэмжих арга хэмжээ авснаас болж хүндрэлд орсон төсвийн нөхцөл байдлын эргэн тойронд эрсдэл их хэвээр байна.

2010 оноос хойшхи үе: Дэлхийн эдийн засгийг дахин тэнцвэржүүлэх нь

Дунд хугацааны туршид байнгын, эрүүл өсөлтөд хүрэх нь хямралаас болж үүссэн нийлүүлэлтийн уналт болон дэлхийн хэмжээний эрэлтийн бүтцийг дахин тэнцвэржүүлэхээс маш их хамаарна.

Боломжит үйлдвэрлэлийн хэмжээ доогуур байна.

Санхүүгийн байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай байна. Ажиллах хүчнийг бизнесийн салбарууд руу буцаан оруулахын зэрэгцээ хөрөнгө оруулалт, бүтээмжийн тогтмол өсөлтийг хангахуйц зээлийн санхүүжилт хийх үүднээс зах зээлд өөрчлөлт хийх шардлагатай. Энэхүү тайлангийн 4-р бүлэгт дурдсан түүхэн баримт нь өнгөрсөн санхүүгийн хямралын үр дагавраар үйлдвэрлэл үндсэндээ томоохон, байнгын цохилгод орж байсныг харуулсан. Хэдийгээр цар хүрээг тодорхойлоход хэцүү ч олон янзын үр дүнд хүрчээ. Боломжит үйлдвэрлэлд хүрч чадалгүй байнгын алдагдалтай байгаагаас дунд хугацааны үйлдвэрлэлийн төсөөлөл нь хямралын өмнөх үеийнхээс маш доогуур байх төлөвтэй байна. Ялангуяа, санхүүгийн болон үл хөдлөх хөрөнгийн хямралд өртсөн эдийн засагт хөрөнгө оруулалт аль хэдийн огцом уналтад орсон байна. Компани дампуурах эсвэл бүтцийн өөрчлөлт хийх үед энэ нь үлдэгдэл өртгийн хувь хэмжээг нэмэгдүүлэхийн хамт идэвхитэй хувьцааг бууруулдаг байна. Мөн түүнчлэн, зарим хөгжингүй улс оронд ажилгүйдлийн түвшин дунд хугацааны туршид өндөр хэвээр байх төлөвтэй.

Эрэлтийн талыг дахин тэнцвэржүүлэх нь.

Эдийн засгийн нийлүүлэлтийн талд өөрчлөлт хийх хүчин чармайлтад дэмжлэг болох зорилгоор хүчтэй сэргэлт тогтмол байлгах үүднээс дэлхийн эрэлтийн бүтцэнд тохируулга хийх шаардлагатай. Ялангуяа, экспортод түшиглэсэн өсөлтийн стратеги баримталдаг, урсгал дансны илүүдэлтэй байдаг олон улс орон дотоодын эрэлт болон импортод илүү найдах хэрэгтэй болж байна. Энэ нь ихэнхдээ урсгал дансны алдагдалтай байдаг, хөрөнгө (хувьцаа эсвэл орон сууц)-ийн үнийн өсөлттэй учирсан эдийн засаг, тухайлбал Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, еврогийн бүсийн зарим орон болон Европын хөгжиж буй олонхи улс орны суларсан дотоодын эрэлтийг хангахад тус болно. Эрэлтийн талд хийгдэх өөрчлөлтийг хангах үүднээс нийлүүлэлтийн талд ч мөн өөрчлөлт хийх хэрэгтэй. Энэ нь олон чиглэлээр, тухайлбал санхүүгийн системд өөрчлөлт хийх арга хэмжээ, компанийн засаглалыг сайжруулах, санхүүгийн зуучлал, төсвийн хөрөнгө оруулалтыг дэмжих, болгоомжилолоос үүдсэн хэмнэлтийг бууруулах үүднээс нийгмийн хамгааллын сүлжээнд шинэтгэл хийх зэрэг арга хэмжээ авах нөхцөлийг бий болгож байна. Бүх улс орнууд эдгээр болон бусад

чиглэлээр шинэтгэл хийхийг маш их хүсч байсан ч дэлхийн хэмжээний эрэлтийг дахин тэнцвэржүүлэх процесс нь үүнийг сунжруулах ба үүнийг дэмжих илүү уян хатан валютын ханш хэрэгтэй болно.

Бодлогын төвөгтэй асуудлууд

Бодлогын гол тэргүүлэх асуудлууд нь санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх, сэргэлт баттай болох хүртэл макро эдийн засгийн бодлогоор дэмжих, бодлогын шийдвэр гаргагчид бас төрийн хэт их оролцоог аажмаар бууруулахад бэлтгэж эхлэх ёстой зэрэг болно. Эдийн засгийн дэмжлэгээ цагаас нь эрт зогсоосноор ойрын хугацаанд илүү их эрсдэл учирч болно. Гэвч хямралаас гарах макро эдийн засгийн дунд хугацааны стратегийг боловсруулах нь санхүүгийн төлбөрийн чадвар, үнийн болон санхүүгийн тогтвортой байдалд итгэл үнэмшил төрүүлэхэд чухал юм. Төрийн оролцооны үргэлжлэх хугацааг зөв тодорхойлох нь төвөгтэй асуудал юм. Төрийн оролцоог хугацаанаас нь эрт болиулбал санхүүгийн тогтвортой байдал, сэргэлтийг хангах тал дээр олсон ахиц дэвшилд аюул учруулж болох ба нөгөө талаар эдгээр арга хэмжээг удаан хугацааны туршид авснаас идэвхийг сааруулж, төсвийн тэнцэлд аюул учруулах эрсдэл бий болно.

Мөнгөний тааламжтай нөхцөлийг хатууруулах цаг

Мөнгөний бодлогын шийдвэр гаргагчдад нь хэзээнээс хатуу бодлого хэрэгжүүлж эхлэх, төв банкны том тэнцлийг хэрхэн задалж үзэх вэ гэсэн гол асуудалтай тулгардаг. Эдгээр хоёр зорилт нь гол зөрчлүүдийг заавал харуулах албагүй. Учир нь төв банкны тэнцэл ердийнхөөс ч илүү том байсан мөнгөний нөхцөлийг чангатгах арга хэрэгслүүд хэрэглэгдсээр л байдаг. Зах зээлийн нөхцөлийг хэвийн байдалд нь оруулах явц, хэрэгжүүлсэн төрийн оролцооны хэлбэрт үндэслэн төв банкны тэнцлийн байдлаас хамааруулан түүнийг задалж үзэх ёстой.

Мөнгөний бодлогыг чангатгах чиглэл рүү шилжих цаг хугацааны хувьд хөгжингүй болон хөгжиж буй улс орнууд харилцан адилгүй бэрхшээлтэй учирдаг. Хөгжингүй улс орнуудын хувьд дотоодын нийт бүтээгдэхүүний зөрүү их байх тусам инфляцийн түвшин доогуур хэвээр байх магадлалтай тул төв банкууд (цөөн тохиолдлоос бусдад) урт хугацаанд мөнгөний тааламжтай нөхцөлийг баримталж болдог. Түүнчлэн, мөнгөний бодлогын шийдвэр гаргагчид төсвийн дэмжлэгийг аажмаар бууруулснаас гарах нөлөөллийг зохицуулах шаардлагатай болдог. Хөгжиж буй улс орнуудын хувьд нөхцөл байдал янз бүр байдаг. Хөгжингүй орнуудыг бодвол хөгжиж буй зарим улс орнуудын хувьд мөнгөний тааламжтай нөхцөлөө богино хугацааны дараа зогсоох нь зохистой байдаг бол зарим улс орны хувьд хөрөнгийн үнийн шинэ хөөрөгдлийн эрсдэлээс хамгаалах болон хөгжингүй орнуудаас хэтэрхий тэлсэн бодлогын үр дүнг импортлохоос зайлсхийх үүднээс валютын ханшийг илүү уян хатан байлгах хэрэгтэй болж мэдэх юм.

2009 оны 10-р сарын Дэлхийн Санхүүгийн Тогтвортой Байдлын Тайлан (GFSR) нь олонхи улс орнуудад наад тал нь дараа жилийн туршид төв банкнаас тогтмол дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байж болох, зарим төв банкны тэнцлээс хөрвөх чадваргүй хөрөнгийг тусгаарлахад илүү урт хугацаа шаардагдах талаар онцлон тусгасан. Үүний зэрэгцээ төв банкууд нь мөнгөний нөхцөлөө чангатгахад шаардагдах нөөц шингээх арга

хэрэгслүүдтэй байдаг. Богино хугацааны бэрхшээлээс гадна мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд хямралын сургамж юу вэ? Түүхэн баримтаас харахад харьцангуй тогтвортой инфляц болон үйлдвэрлэлийн өсөлт нь хөрөнгийн үнийн хөөрөгдөл (бүтээгдэхүүн болон инфляц нь хөрөнгийн үнийн хөөрөгдлийг сайн урьдчилан мэдээлж чаддаггүй)-өөс эдийн засагт үзүүлэх гол цочролын эсрэг авах хүчтэй хамгаалалт болж чаддаггүй. 3-р бүлэгт бусад үзүүлэлтүүд, тухайлбал анхаарал татаж буй зээлийн өсөлт болон урсгал дансны байдал нь илүү сайн урьдчилан мэдээлэгч болдог бөгөөд мөнгөний бодлогын шийдвэр гаргагчдын анхаарлын төв байх ёстой талаар өгүүлсэн. Иймд, дотоодын зах зээлийн эрэлт болон хөрөнгийн үнийн өсөлт гол асуудал болж буй нөхцөл байдалд мөнгөний бодлогын шийдвэр гаргагчид нь дараагийн 1-2 жилд инфляцийг өөрсдийн хяналтад байлгах зорилгоор мөнгөний бодлогоо шаардагдах хэмжээнээс илүү чангаруулах арга хэмжээ авах ёстой. Мөн энэхүү бүлэгт мөнгөний бодлогын шийдвэр гаргагчид нь эдийн засгийг тогтворжуулахад туслах макро түвшний зохистой арга хэрэгслийн хамт инфляцийг онилох асуудлыг авч үзнэ. Макро түвшний зохистой арга хэрэгсэл нь зээлийн мөчлөгт үндэслэн шууд ашиглаж болох давуу талтай бөгөөд иймд эдийн засгийг тогтворжуулахад хүүний түвшний үүргийг давхар гүйцэтгэнэ. Гэхдээ хүрэх онцгой үр дүн нь бодитой байх ёстой.

Төсвийн дэмжлэгийг төсвийн тогтвортой байдлыг хангах зорилттой уялдуулах нь

Ихэнхи улс орнуудад төсвийн алдагдал өндөр хэмжээтэй байгаа, төсвийн зардал өссөнийг үл харгалзан сэргэлт тогтвортой болох хүртэл төсвөөс үзүүлэх эдийн засгийн дэмжлэгийг тогтмолжуулах шаардлагатай. Өсөлтөд эрсдлийн үзүүлэх хор уршиг бодитой болсон нөхцөлд энэ арга замыг тухайн үеийн төлөвлөгөөнөөс ч илүү хэрэглэж болох юм. Мөн Засгийн газрууд шаардлагатай гэж үзвэл шинэ идэвхи санаачилгыг хэрэгжүүлэхэд бэлэн байх ёстой. Харин сэргэлт тогтвортой болмогц засгийн газрууд алдагдлыг их хэмжээгээр бууруулахын төлөө ажиллах ёстой. Мөн төсвийн санхүүжилтийг илүү тогтвортой чиглэлд зориулах замаар шинэтгэлийг гүнзгийрүүлж төсвийн урт хугацааны асуудалд анхаарал хандуулж эхлэх хэрэгтэй. Алдагдлыг ихээхэн хэмжээгээр бууруулахад тохиромжтой төсвийн зарчим, хэрэгжүүлэх хүчтэй механизм зэрэг илүү эрүүл төсвийн хүрээ ач холбогдолтой. Ийм зарчим болон хүрээ нь сайн цаг үе эргэн ирэх үед зардлын дарамтыг хязгаарлахад чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд ингэснээр алдагдал болон өр төлбөр яваандаа буурна гэсэн итгэлийг хөрөнгө оруулагчдад дахин төрүүлнэ. Энэ нь мөчлөгийн эсрэг нөлөөллийн дор авах бодлогод ихээхэн орон зайг дахин бий болгож, санхүүгийн зах зээлд үзүүлэх төсвийн дэмжлэгийг сэргээх бөгөөд эдгээрийн аль аль нь ирээдүйд үүсэх цочролд хариу үзүүлэхэд хэрэгтэй юм.

Зохистой байдлын хүрээнд хийх шинэтгэлийг санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх зорилготой уялдуулах нь

Санхүүгийн салбарыг сайжруулах үйл ажиллагааг дуусгавар болгож тогтвортой хөгжлийг дахин сэргээх үүднээс зохистой байдлын хүрээнд шинэчлэл хийх нь маш их ач холбогдолтой.

Санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд бүтцийн өөрчлөлт хийх явдал нь зээлийн хэвийн үйл ажиллагааг дахин сэргээхэд чухал юм. 2009 оны 10-р сарын

GFSR-т энэ талаар илүү гүнзгийрүүлэн тайлбарласнаас үзэхэд шинэчлэлд тайлан тэнцлийг цэвэрлэх, дахин хөрөнгөжүүлэх болон санхүүжилтийн шинэ загварууд болон зохистой байдлын шинэ хүрээг тусгасан бизнесийн шинэ төлөвлөгөө шаардах зэргийг хамруулсан байна.

Одоогоор банкны тайлан тэнцлээс муу активыг цэвэрлэх үйл ажиллагаанд маш бага ахиц гарсан байна.

Активын чанар улам бүр муудаж байгаа нь гол хүндрэл болж байна. Үүнтэй холбогдуулан албан ёсны цочролын сорил хийх нь чухал алхамд гарцаагүй тооцогдоно. Дахин хөрөнгөжүүлэх, амьдрах чадвартай банкуудад бүтцийн өөрчлөлт хийх болон амьдрах чадваргүй банкуудын асуудлыг болгоомжтой шийдвэрлэх зорилгоор банкуудын байдалд дүн шинжилгээ хийхэд эдгээр арга хэрэгслийг ашиглана. Улс орнуудад харилцан адилгүй ахиц ажиглагдаж байгаа бөгөөд дахин хөрөнгөжүүлэх асуудал нь улс төрийн саадтай тулгарах тул санаа зовоосон нэг асуудал болж байна. Стратегийн шийдэл нь зах зээлийг зөв чиглүүлэхэд туслалцаа үзүүлэх ёстой.

Банкууд давтагдах эрсдэлийг нэмэгдүүлэх “wall of maturities”/”хугацаа дууссаны хаалт”-тай ирэх 2 жилд нүүр тулах болно. Төсвийн дэмжлэгт аль болох найдахгүй байлгах үүднээс зах зээлд үндэслэсэн идэвх санаачилгыг дэмжих замаар хөтөлбөрүүдийг ээлж дараатайгаар маш аажмаар хумих хэрэгтэй.

Хямралын том аюул ард хоцорлоо гэсэн өсөн нэмэгдэж буй итгэл найдвар, улс үндэсний өрсөлдөх давуу тал алдагдана гэсэн айдас, эсвэл техникийн шалтгааны улмаас хамгийн эхний сайн шийдвэрт хүрч чадахгүй гэсэн сэтгэл зовсон байдлаас болж шинэтгэлийн гол үр дүнд аюул учирах ёсгүй. 10-р сарын GFSR нь дараах 4 төвөгтэй асуудалд гол анхаарлаа хандуулсан. Нэгд, зохицуулалтын хамрах цар хүрээг цаашид өргөжүүлж илүү уян хатан болгох. Ингэхдээ одоогийн байдлаар “унахад хэтэрхий том эсвэл хэтэрхий олон хэлхээ холбоотой” гэж үзэж буй байгууллагуудыг цаашид нэмэгдэхээс зайлсхийж, системийн хэмжээнд чухал гэж үзсэн дэмжлэг үзүүлэхэд тохирох бүх байгууллагыг хамруулна. Хоёрт, ил тод байдлыг нэмэгдүүлэх, санхүүгийн байгууллагын засаглалыг тодорхой болгож шинэчлэх замаар үр ашигтай зах зээлийн сахилга батыг дэмжих. Гуравт, макро түвшний зохистой байдлын хүрээ нь банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх, хүнд үед ашиглах зорилгоор сайн цагт хөрөнгөө нэмэгдүүлж нөөцийн сан байгуулахад түлхэц үзүүлнэ. Дөрөвт, хил дамнасан харилцаатай байгууллагуудад тулгарах хүндрэлүүдийг зохих ёсоор давж гарах үүднээс олон улсын хамтын ажиллагаа болон зохицуулалтыг сайжруулах ёстой.

Бүтцийн болон нийгмийн бодлогын чиглэлээр тавигдах асуудлууд

Олонхи хөгжингүй орнуудад ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, дийлэнх хөгжиж буй орнуудад ядууралын түвшин өндөр хэвээр байгаа нь гол шийдвэрлэх асуудал болж байна. GFSR-ийн 4-р бүлэгт санхүүгийн цочролын дараагаар ажилгүйдлийн түвшин ихээхэн хэмжээгээр нэмэгдэж олон жилийн туршид уг түвшин хэвээр хадгалагдах хандлагатай байдаг талаар зөвлөсөн байна. Ажлын байрны бууралтад хязгаарлалт хийх нь цалин хөлсний өсөлтийг удаашруулах буюу олон ажилчдын цалинг бууруулахад хүргэнэ. Ажиллах хүчний шаардлага хангахгүй байгаа хэсэгт хэрэгцээтэй зохицуулалтын үр нөлөөг олсон орлогод татварын хөнгөлөлт үзүүлэх эсвэл цалин хөлсний зохицуулалтаас гарах нийгмийн үр дагаврыг багасгадаг үүнтэй төстэй

хөтөлбөрийн үр дүнд зөөлрүүлж болно. Түүнчлэн, илүү тохирсон ажил, эзэмшсэн боловсрол болон хамрагдсан сургалт зэрэг нь ажлын байраа алдахгүй байх эсвэл цалин хөлс буурахгүй байхад дэмжлэг болно.

Зарим хөгжиж буй улс орон, ялангуяа 2009 онд нэг хүнд ногдох ДНБ-ий бодит хэмжээ нь сүүлийн 10 жилд анх удаа буурсан Сахарын бүсийн Африкын орнуудад ядуурал улам тэлэхээр байна. Хэрэв эдгээр улс орон макро эдийн засгийнхаа тогтвортой байдлыг хангахад маш их санхүүжилт гаргах шаардлагатай байгаа бол хөгжингүй улсуудаас дэмжлэг үзүүлэх нь маш чухал юм.